



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ОРА-2021/71/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг

2021 он

Тэргүүлэх аудитор: Ц.Нармандах

Утас: 70358033

Цахим хаяг: Narmandakh.ts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Эрдэнэ

Утас: 70355805

Цахим хаяг: Erdene.b@audit.gov.mn

Аудитор: О.Гантуяа

Утас: 70357955

Цахим хаяг: Gantuya.o@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	<b>Error! Bookmark not defined.</b>
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан .....	5
3.1. Ерөнхий зүйл.....	5
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	5
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	5
3.4. Материаллаг байдал .....	6
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт .....	8
Залруулсан алдаа .....	
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	8
Аудитын зөвлөмж.....	
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	9
4. Менежментийн захидал .....	<b>Error! Bookmark not defined.</b>
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	<b>Error! Bookmark not defined.</b>

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2021.02.25 № 80

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ХОТЫН  
ЗАХИРАГЧИЙН АЛБАНЫ ДАРГА  
С.ГАНЦОГТ ТАНАА

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Хотын захирагчийн албаны дарга С.Ганцогт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь “нэгээс дээш тайлант хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө” гэсэн заалтыг зөрчин бараа материалын дансанд 2,680.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй ус буцалгагч, ус цэвэршүүлэгч, хөшиг, дуу хураагчийг бүртгэж тайлагнасыг, цаашид бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бүртгэж тайлагнахгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Эрдэнэ, аудитор О.Гантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 27 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Хотын нийгэм, эдийн засаг зэрэг хотын аж ахуйг зохион байгуулах мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулан удирдах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 119,838.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,198.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон бол, гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлого 251,051.7 мянган төгрөг болж өөрчлөгдсөн тул 1 хувиар буюу 2,510.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 114,583.0 мянган төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	13,298.6	18,502.9	5,204.3
Үндсэн хөрөнгө	141,749.1	21,961.8	-119,787.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>155,047.8</b>	<b>40,464.8</b>	<b>-114,583.0</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	155,047.8	40,464.8	-114,583.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>155,047.8</b>	<b>40,464.8</b>	<b>-114,583.0</b>

Мөнгөн хөрөнгө, авлага болон урьдчилгаа дансанд үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 18,502.9 мянган төгрөг болж 5,204.3 мянган төгрөгөөр өссөн нь бэлэн бүтээгдэхүүн дансны үлдэгдлээс шалтгаалжээ. Энэ нь төсвийн хөрөнгөөр 5,307.4 мянган төгрөгийн бараа материал, нэмэлт данснаас 5814.0 мянган төгрөгийн хулдаасан хэвлэлийг орлогод авч 7,141.8 мянган төгрөгийн материалыг зарлагадан 4,097.6 мянган төгрөгийн усны гутал, борооны цув, толгойн гэрэл зэрэг материалын үлдэгдэл, бичиг хэргийн зардалд 6,089.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал худалдан авч 4,925.7 мянган төгрөгийн материал зарлагдан 1,435.3 мянган төгрөгийн бичгийн А4, А3 цаас, принтерийн хор, хард диск зэрэг бичиг хэргийн материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 141,749.1 мянган төгрөг байснаас 21,961.8 мянган төгрөг болж 119,787.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь 21,377.9 мянган төгрөгийн тайлант оны элэгдлийн зардал, 129,000.0 мянган төгрөгийн үнэтэй, 19,350.0 мянган төгрөгийн элэгдлийн зардалтай тоёото прадо-150 авто машиныг аймгийн ЗДТГ-т шилжүүлж, 49,000.0 мянган төгрөгийн үнэтэй элэгдэл нь дууссан хьюндей азера авто машиныг шилжүүлэн авснаас шалтгаалсан байна.

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас орон нутгийн хөрөнгө оруулалтаар 8,646.0 мянган төгрөгийн 3 ширхэг суурин компьютер, 2,594.6 мянган төгрөгийн архивын шүүгээ нийт 11,240.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг тоног төхөөрөмж болон тавилга эд хогшилд орлого авч бүртгэсэн байна.

2020 оны санхүүгийн тайланд биет бус хөрөнгө, өр төлбөр дансанд урт болон богино хугацаат өр төлбөр бүртгэгдээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 40,464.8 мянган төгрөг болж тайлант үеийн үр дүнгээр буурсан байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 89,727.7 мянган төгрөгөөр буюу 25.4 хувиар өссөн байна. Энэ нь өмнөх онд 131,301.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө, бараа материал бүртгэсэн бол тайлант онд 11,404.4 мянган төгрөгийн үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө бараа материал орлогоор бүртгэсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 14,039.4 мянган төгрөгөөр буюу 6.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс цалин 11,637.1 мянган төгрөг, НДШ 2,302.4 мянган төгрөгөөр зардлууд өссөн байна. Энэ нь МУ-ын засгийн газрын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 472 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 сараас цалин нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт, нягтлан бодох бүртгэлийн залруулга бүртгэгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс нийт зарлагыг 221,958.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 12,962.5 мянган төгрөгөөр өсгөж нийт зардлыг 234,921.3 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 234,921.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 234,921.3 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 234,921.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 214,251.1 мянган төгрөгийг зарцуулж, 20,670.2 мянган төгрөгийн зардлын хэмнэлтийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын хэмнэлт 20,670.2 мянган төгрөг буюу 8.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 29,264.1 мянган төгрөг, НДШ-ийн зардал 2,457.5 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах зардлыг 2,337.5 мянган төгрөг, урсгал засварын зардлыг 48.0 мянган төгрөг, томилолтын зардал 164.7 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 141.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 510.7 мянган төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар Erdenethot.mn сайтыг хөгжүүлэхэд 9,990.0 мянган төгрөг, гудамж талбайд эрчим хүчээ хэмнэх, хэт ачаалал үүсгэхгүй байх усны хэрэглээндээ хяналт тавих уриалгыг байршуулахад 6,140.4 мянган төгрөг нийт нийт 16,130.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 143 мэдээлэл, 2 мэдээлэл хугацаа болоогүй, 4 мэдээлэл хугацаа хоцроож, 250,057.9 мянган төгрөгийн 14 орлогын 15,570.0 мянган төгрөгийн 2 зарлагын мэдээллийг мэдээлсэн байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт							
Албан шаардлага							
Зөвлөмж	2		2				
Нийт дүн	2		2				

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,849.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 1,168.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 2,680.8 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа байхгүй залруулга хийгдээгүй байна.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 3,849.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,168.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

1. Тайлант онд бичиг хэргийн зардлаас 359.9 мянган төгрөгийн хард диск, шуудан холбооны зардлаас 250.4 мянган төгрөгийн телефон утасны аппарат, нэг удаагийн тэтгэмжээс 558.0 мянган төгрөгийн амин дэм авч, нийт 1168.3 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Цалинг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Зардлын данстай холбоотой

1.1. Илрүүлэлт:

Бараа материалын дансанд 2,680.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй ус буцалгагч, ус цэвэршүүлэгч, хөшиг, дуу хураагчийг бүртгэж тайлагнасан УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь "нэгээс дээш тайлант хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнахгүй байх.

Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Орхон аймгийн Хотын захирагчийн албанд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллахаар 2021.02.24-ны 59 тоот албан бичгээр хариуг ирүүлж, хүлээн зөвшөөрсөн болно.

ХЯНАСАН:  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР



АУДИТЫН ТАЙЛАНГ

Ц.НАРМАНДАХ

Б.ЭРДЭНЭ

О.ГАНТУЯА

Огноо:

Огноо:


Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо: 2021	Аудитын нэр:	Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/71/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Орхон аймгийн Хотын захирагчийн алба		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Тайлант онд бичиг хэргийн зардлаас 359.9 мянган төгрөгийн хард диск, шуудан холбооны зардлаас 250.4 мянган төгрөгийн телефон утасны аппарат, нэг удаагийн тэтгэмжээс 558.0 мянган төгрөгийн амин дэм авч, нийт 1,168.3 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	1,168.3	Албан шаардлага	Дарга, нягтлан бодогч	С.Ганцогт, Н.Ариунзаяа
2	Бараа материалын дансанд 2,680.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинжтэй ус буцалгагч, ус цэвэршүүлэгч, хөшиг, дуу хураагчийг бүртгэж тайлагнасан байна.	2,680.8	Зөвлөмж	Дарга, нягтлан бодогч	С.Ганцогт, Н.Ариунзаяа
<b>ДҮН</b>		<b>3,849.1</b>			

**АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ**

ХЯНАСАН: ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРМАНДАХ	Огноо:
АУДИТЫН МЕНЕЖЕР		Б.ЭРДЭНЭ	Огноо:
БЭЛТГЭСЭН: АУДИТОР		О.ГАНТУЯА	



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 90/90 ОМ-2021/71/СТА-ТШЗ

Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Хотын захирагчийн албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бичиг хэргийн зардлаас 359.9 мянган төгрөгийн хард диск, шуудан холбооны зардлаас 250.4 мянган төгрөгийн телефон утасны аппарат, нэг удаагийн тэтгэмжээс 558.0 мянган төгрөгийн амин дэм авч, нийт 1,168.3 мянган төгрөгийн зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41.2.3-д "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.", 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хотын захирагчийн албаны дарга С.Ганцогт, нягтлан бодогч Н.Ариунзаяа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР: ..... Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН  
МЕНЕЖЕР: ..... Б.ЭРДЭНЭ

АУДИТОР: ..... О.ГАНТУЯА